

МОНГОЛ УЛСААС ОЛДСОН ШИ ГЭ-ГИЙН БЭХЭН БИЧЭЭСИЙН ТУХАЙ

МАЦУДА КОИЧИ

Товч агуулга: Монгол-Японы хамтарсан “Бичээс III” төслийн судлаачид 2013 оны 9-р сард Монгол улсын Архангай аймгийн Ихтамир сумын нутаг дахь Тайхар чулуунаас ханз үсгээрх бэхэн бичээсийг шинээр олов. Энэ өгүүлэлд, Юань улсын судар зэрэг хятад сурвалж болон өмнөх судалгааны үр дүнд тулгуурлан, тэрхүү бичээсийг 1237 онд Юань улсын Жэндин замын захирагч Ши Тяньзэ-гийн ахмад хүү Ши Гэ бичсэн болохыг олж тогтоов.

Түлхүүр үг: Тайхар чулуу, бэхэн бичээс, Жэндин, Ши Гэ, Хангай дахь Тулуйн нутаг.

1. Бэхэн бичээс олсон нь¹

Зураг 1-д үзүүлсэнчлэн, Тайхар чулуу нь тэгш талд оршдог. Тайхар чулууны тойргийн урт 68.9 м,² харин өндөр нь 20 м орчим болов уу. Бид 2013 оны 9-р сарын 6-ны өдрийн 15 цагийн үед Тайхар чулуун дээр очиж, судалгааны ажил гүйцэтгэсэн юм. Сүүлийн үед Тайхар чулуунд кирилл үсэг зэргээр элдэв зүйл зурж бичих явдал гарч буй авч эртний рүни, уйгур, монгол, манж, төвд бичгээрх бэхэн бичээс ч буй.³ Тэр мэт эртний Тайхар чулууны бичээсний тухай Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал, сэдэвчилсэн лавлах⁴-д дэлгэрэнгүй дурдсан буй.

Манай судалгааны багийнхан Тайхар чулууны гадаргууг нэг бүрчлэн шалгаж, хэдийн тодорхой болсон уйгур үсгийн уйгур хэлээрх бэхэн бичээсийн гэрэл зургийг авах үед, тэрхүү уйгур бичээсийн зүүн гар талд Зураг 3-т үзүүлсэн ханз үсгийн бэхэн бичээсийг миний бие олж харав. Энэ нь дээр дурдсан лавлахад нийтлэгдсэн ханз үсгийн 2 бэхэн бичээсээс өөр, шинэ бичээс байв.

¹ “Бичээс III” төсөл хэрэгжүүлэх гэрээг 2009 оны 11 дүгээр сарын 5-нд Японы талаас Осакагийн Олон улсын их сургуулийн профессор (одоо хүндэт профессор) Мацүда Коичи, Монголын талаас Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн захирал, академич Б.Энхтүвшин нар гарын үсэг зурж байгуулсан болно. Монгол-Японы хамтарсан “Бичээс III” төслийн 2013 оны зуны судалгааны ажил 9 дүгээр сарын 1-нээс 7-ны хооронд үргэлжилж, Японы талаас Мацүда Коичи (Осакагийн Олон улсын их сургуулийн хүндэт профессор), Мүраока Хитоши (Рюүкоку их сургууль), Мацүкава Такаши (Оотани их сургууль), Монголын талаас А.Очир (Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн) нар оролцов.


² Takao Moriyasu, Ayudai Ochir, *Provisional Report of Research on Historical Sites and Inscriptions in Mongolia from 1996 to 1998*, The Society of Central Eurasian Studies, 74. 1998 онд Уно Нобүхиро-гийн гүйцэтгэсэн хэмжилтийн тэмдэглэл.

³ Мөн тэнд., 26.

⁴ *Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал, сэдэвчилсэн лавлах*, Бүтээлийг эрхэлсэн Лувсандамбын Дашням ба бусад, УБ, 1999, 222-225.

Энэхүү ханз үсгийн бэхэн бичээс нь Тайхар чулууны баруун талын гадаргууд газраас дээш ойролцоогоор 50-60 см-т, шагайж харвал харагдахаар байна. Тайхар чулууны өмнө байх жижиг хадан дээр зохиогч сууж үзэхэд, бичээс нь харааны шугмаас бага зэрэг дор харагдах ба Тайхар чулууны шовх үзүүр дор сүүдэр тусах газар тул эдүгээ хүртэл нүдэнд өртөлгүй ирсэн болов уу.

Газрын зураг 1



2. Бэхэн бичээсийн агуулга

3	2	1
真定史格題	到此	丁酉歲秋八月□

Бэхэн бичээсийн агуулгыг дурдвал, юуны өмнө Зураг 3-5-аас сийрүүлэн сэргээх боломжтой үсгийг дурдвал дараах мэт.

Нэгдүгээр мөр: 丁酉歲秋八月□ буюу “Улаагчин тахиа жилийн намар найман сарын ...”

Улаагчин тахиа жил нь европын тоололын хэдэн он гэдгийг шууд хэлж үл болно. Харин доор дурдахчилан, улаагчин тахиа жил нь 1237 он гэдгийг тогтоов.


Энэ мөрийн хамгийн сүүлийн үсэг □ буюу баларсан үсэг нь байрлалын хувьд сар өдрийн өдрийг тавих ёстой газар болно. Ганц үсэг байгаа учир “朔” (“шинийн нэгэн”) юм уу, “望” (тэргэл өдөр) хэмээх үсэг байж болох мэт авч



Зураг 1. Тайхар чулуу




Зураг 2. Тамирын голын баруун эрэг буюу өмнө талд орших Улаанчих уул. Тамирын голын баруун эрэг буюу өмнө талд оршино. (баруун өмнө талаас)



Зураг 3. Бэхэн бичээсийн ерөнхий байдал.



Зураг 4. Нэгдүгээр мөрийн хамгийн сүүлийн балархай үсэг.



Зураг 5. Гуравдугаар мөрийн “史格 Shi Ge” буюу Ши Гэ.

баттай бус. Тэгээдч үсгийн хэлбэр нь “記”(бичиж тэмдэглэх) үсэг шиг харагдах тул одоогоор тодорхой хэлж үл чадна.

Хоёрдугаар мөр: 到此 буюу энд хүрээд. “此”(энд) нь Тайхар чулууны байршлыг заасан үг гэдэг нь тодорхой байна.

Гуравдугаар мөр: 真定史格題. Эхний хоёр үсэг “真定 Zhengding” буюу Жэндин нь одоогийн БНХАУ-ын Хэбэй мужийн Шижиажуан (Shijiazhuang, 石家莊) нутаг болно. Жэндин нь Юань улсын үеийн нэр бөгөөд анх Жэндин фу (Zhengding fu, 真定府), хожим Жэндин зам (Zhending-lu, 真定路) хэмээх болсон. Дараагийн хоёр үсэг нь “史格 Shi Ge” буюу Ши Гэ нь Монголын эзэнт улс буюу Юань улсын үеийн Жэндиний захирагч Ши Тяньзэ (Shi Tianze, 史天沢)-гийн ахмад хүү болно. Сүүлийн үсэг “題 ti” нь “бичиж үлдээв” хэмээх утгыг илэрхийлнэ. Тиймээс энэхүү бичээс нь, “1237 оны намар найман сарын -ны өдөр, Тайхар чулуун дээр ирсэн Жэндиний Ши Гэ бичив” хэмээх утгатай болж байна.

3. Бэхэн бичээсийн түүхэн нөхцөл

Эхлээд Жэндин-гийн Ши Гэ гэгч хүний тухай авч үзье. Жэндиний гэгдэх Ши Гэ-ийн тухайд, Юан улсын судар, дэвтэр 155, Ши Тяньзэ-гийн шастирт, Ши Тяньзэ-гийн ахмад хүү гэжээ. Ши Тяньзэ бол Жэндин (Газрын зураг 2-ыг үзнэ үү) нутгийн уугуул, Чингис хаан Алтан улсын нутгийг (одоогийн БНХАУ-ын нутаг дэвсгэр) довтлоход хамгийн түрүүнд түүнд дагаар орсон хятад газрын цэргийн хүн болно.⁵ Тайхар чулууны бичээст нэр гарах Ши Гэ бол энэхүү Ши Тяньзэ-гийн ахмад хүү Ши Гэ мөн болов уу.

Тэгвэл бичээсийг бичсэн улаагчин тахиа буюу 1237 онд Ши Гэ хэдэн настай байсан бэ. Хэдий Ши Тяньзэ-гийн шастирт Ши Гэ-гийн намтрыг мөн хавсаргасан байх боловч Мөнх хааны үед 1251 онд түшмэлээр томилогдсоноос хойших үйл явдлыг л тэмдэглэсэн байна. Гэвч түүний нас барсан оныг дурдсан тул 1237 онд бичээс бичих үед хэдэн настай байсныг олж болно. Юань улсын судраас үзвэл, Ши Гэ Хубилайн үед Өмнөд Сүн дайлах цэрэгт явж, Гуанжоу мужийн Яшань (Ya-shan, 崖山) аралд Өмнөд Сүнгийн хааны удмынханыг мөхөөсний дараа, хэд хэдэн удаа тушаал дэвшсэн бөгөөд 58 настайдаа нас баржээ. Тийнхүү нас барсан он нь Өмнөд Сүн улс мөхсөн 1279 он гэвэл, түүний төрсөн он нь 57 жилийн өмнөх 1222 он болно. Тайхар чулууны бичээс дэх улаагчин тахиа жил буюу 1237 онтой харгуулбал, 1237 онд Шигэ 16 (хий нас оруулаад) настай байсан болно. Гэхдээ Ши Гэ-гийн хэд хэдэн удаа тушаал дэвшсэнийг харгалзан үзвэл, нас барсан он нь Өмнөд Сүн улс мөхсөнөөс хойш мэт бөгөөд чингэж бодохул

⁵ Ike-uchi Isao, Shi shi ichizoku to mongoru no kinkoku keiryaku, *Nakajima Masatoshi sensei koki kinen ronshū* 1, Kyūko shoin, 1980, 481-511.

төрсөн он нь 1222 оноос хойш, улмаар 1237 онд 16 нас хүрээгүй байсан болно.

Тийнхүү Тайхар чулууны бичээст нэр гарах Ши Гэ-г Ши Тяньзэ-гийн ахмад хүү Ши Гэ мөн гэвэл, тэрбээр 16 буюу түүнээс бага насандаа Тайхар чулуун дээр ирэх ямар учир шалтгаан байв гэдэг асуулт гарна.

Юан улсын судар дахь Ши Тяньзэ-гийн шастираас үзэхэд, 1229 онд Өгөдэй хаан ширээнд суух үед Хэбэй мужийн Жэндин зэрэг 5 зам (Zhending 真定, Hejian 河間, Daming 大名, Dong ping 東平, Jinan 濟南)-ын түмэнээр томилогдож, Жэндинд төвлөн суужээ. 1234 онд монголын цэрэг Алтан улсын хааныг Өмнөд Сүн улсын хилийн ойролцоох Цайжоу (Cai-zhou, 蔡州)-д мөхөөсний дараа тэдэнд дагаар орсон Ши Тяньзэ Жэндинд буцан ирж, монголчуудад хүчин зүтгэжээ. Тухайлбал, 1235 онд Өгөдэй хааны гуравдугаар хөвгүүн Гүчү (Güchü) Өмнөд Сүн улсыг довтлоход болон 1237 онд Хүүн Буха (Kö'ün Buqa) ноён Гуанжоу (Guangzhou, 光州)-г довтлоход оролцжээ. Харин түүнээс хойш 1251 онд Мөнх хаан ширээнд суух хүртэлх үеийн үйл ажиллагааны талаар тэмдэглэсэнгүй.

1237 оноос хойшх Ши Тяньзэ-гийн гавьяа зүтгэлийн талаар Ван Юнь (王惲, Wang Yun) эмхэтгэсэн “Чинү Жян багштаны бүтээлийн бүрэн эмхэтгэл 秋澗先生大全文集”-ийн 48-р дэвтэр, “Ши Гүн гэрийн шастир 史公家伝”-т, 1238-1239 онд Жэндинд болсон үйл явдал хэмээгээд, “Даргач Мөнхсар монгол цэрэг, тэдний гэр бүлийн хэдэн түмэн хүнийг Жэндиний жоу, чүн (zhou qun 州群, засаг захиргааны нэгж)-д хуваан суулгав. Тэдгэр барих газар гаргахын тулд ялам модыг тайрч, тариан талбайг гишгэлж, тариачидамь зуух аргагүй болов. Үүнд Ши Тяньзэ газрын эзэн буюу Сорхогтан бэхи хатанд дээрх явдлыг өргөн мэдүүлж, улмаар монгол цэрэг, тэдний гэр бүл бүгдийг Давааны арын нутаг буюу уугуул монгол нутаг руу нүүлгэв. Түүний үр дүнд тариачдын урам зориг сэргэж, өнөөг хүртэл Жэндиний цэрэг, тариачид бусад газраас илүү болсон нь Ши Тяньзэ-гийн өгөөмөр бодлогын үр шим юм” хэмээжээ. Өөрөөр хэлбэл, Сорхогтан бэхи харьяат цэрэг, тэдний гэр бүлийг Жэндинд суулгаж нутаглуулах гэсэн хэрэг гарч байжээ.

Ши Тяньзэ-гийн төвлөн суусан Жэндин нь Өгөдэй хаан Алтан улсыг дайлсаны дараа жил буюу 1236 оны улаан бичин жил монгол ноёдод эзэмшил нутаг, иргэн олгоход Чингис хааны отгон хүү Тулуйд оногдсон нутаг юм. Тулуй Алтан улсыг эзлэх дайнд оролцсон авч 1232 онд нас барсан тул түүнд оногдсон эзэмшил нутаг, иргэнийг Тулуйн хатан Сорхогтан бэхи мэдэж захирах болжээ.⁶

Сорхогтан бэхи нь Тулуйн дөрвөн хүү Мөнх, Хубилай, Хүлэгү, Аригбөх нарыг төрүүлсэн бөгөөд Тулуйг нас барахад, өв хөрөнгийг тэр даруй хуваалгүй, Сорхогтан бэхи хатан гэр бүлийн өмчийг ерөнхийлөн мэдэж байв. Тулуйн өв

⁶ Matsuda Koiichi, Wokuotai han no 'Heishinnen bunbatsu' saikō 1: 'Dali zhenguan renwei' no Neikaishū bunchi ni tsuite, *Xiyu lishi yuyan yanjiu jikan* 4, Zhongguo renmin daxue guoxueyuan, Xiyu lishi yuyan yanjiu suo, 2010, 115-134.

хөрөнгийг хуваасан нь ахмад хүү Мөнх дөрөв дэх хаанаар өргөмжлөгдсөн 1251 оноос хойшх явдал болно.⁷ 1232 онд Тулуй нас барснаас хойш наад зах нь 1251 ондахмад хүү Мөнх хаан ширээнд суух хүртэлх хугацаанд, Тулуйн Монгол нутаг дахь эзэмшил газар, харьяат ардхийгээд 1236 оны улаан бичин жилд монгол ноёдод эзэмшил нутаг, иргэн олгоход оногдсон Хятад дахь эзэмшил нутаг Жэндиний газар, иргэдийг бэлэвсэн хатан Сорхогтан бэхи захирч байв.⁸

Тиймээс 1236 оны “Улаан бичин жилийн газар, иргэн хуваарилалт”-аас хойш Ши Тяньзэ нь Тулуйн гэр бүлийн Хятад нутаг дахь эзэмшил нутаг Жэндинийг захирах тэргүүн түшмэл буюу Сорхогтан бэхи хатны удаах байр суурийг эзэлж байжээ. Дээр дурдсан 1238-1239 онд Жэндинд гарсан хэрэгтэй холбогдон нэр гарах даргач Мөнхсар нь Сорхогтан бэхи хатнаас Жэндинд суулгасан монгол талын захирагч, харин Ши Тяньзэ нь Жэндиний хятад талын захирагч болно. Ши Тяньзэ нь тухайн үед Жэндинд үүссэн нөхцөл байдлыг Тулуйн гэр бүлийг тэргүүлэх Сорхогтан бэхи хатанд өргөн мэдүүлж, асуудлыг шийдвэрлэсэн аж.

Жэндин нь Тулуйн гэр бүлийн эзэмшил нутаг болмогц, Сорхогтан бэхи хатан Уйгурын сайд асан Сэвинч Тоорил (Sevinchi To'oril)-ыг уг газрын заргач бөгөөд Жэндийн замын их даргачаар томилон суулгахын⁹ зэрэгцээ Гуйюн сан (Gui-yun ku, 規運庫) хэмээх газар байгуулан, Гао Лянби (Gao Liangbi, 高良弼) гэгчийн тэргүүнээр (shi, 使) томилж,¹⁰ хятад дахь эзэмшил нутгийн засаг захиргаа, санхүүг захиран мэдэх болсон юм. Түүний дараахан дурдсан даргач Мөнхсар (Сэвинч Тоори́лын дараа томилогдсон болов уу)¹¹-ын үед гарсан хэрэг болж байна.

⁷ Судрын чуулганы Мөнх хааны тэмдэглэлд дурдсанаар, 1252 оны 2-3-р сард Сорхогтан бэхи нас барж, мөн онд Жэндиний өмнөд этгээдэд Хубилай (Huai Menglu, 懷孟路), Хүлэгү (Zhang Delu, 彰德路) нар шинээр эзэмшилтэй болжээ. Аригбөх ч мөн 1255 онд Жэндин замд зарлиг буулгасан Chen Tao, 沈濤編, Zhangshan Zhenshi zhi 常山貞石 15, Dachao Guoshi Namodaishi Chongxiu Zhendingfu Dalong Xing si Gongdeji 大朝國師南無大土重修真定府大龍興寺功德記 байх тул тэр хүртэл Жэндин дэх эзэмшлийг үе залгамжилж байжээ. Мөнх хаан ширээнд суусан 1251 оноос хойш, Сорхогтан бэхи нас барсан 1252 оны хооронд Тулуйн гэр бүлийн эзэмшил нутаг, иргэнийг хуваасан болов уу.

⁸ Matsuda Kōichi, Hureguke no tōhōryō, Tōyōshi kenkyū 39-1, 1980, 38-39, 42-43. 姚燧 Yao Sui, Mu-an-ji 牧庵集 дэвтэр 23, You yuan gushao zhongdafa huai-an-lu zongguan jian fu yinjian guan-nei quannong-shi gaogong shendaobei 有元故少中大夫淮安路總管兼府尹兼管内勸農事高公神道碑-нд Өгөдэй хаан Жэндинг Тулуйд эзэмшил газар болгон өгсөн боловч Тулуй нэгэнт нас барсан учир Сорхогтан бэхи хатан (Zhuangsheng Taihou, 莊聖太后) уг нутгийг эзэмшин захирах болсон гэж буй.

⁹ Hashan shendaobei 哈珊神道碑, Chen Tao 沈濤, Zhangshan zhenshizhi 常山貞石志 21; Юань улсын судар, дэвтэр 134, Сэвинч Тоори́лын шастир. Энэ хоёр сурвалжид, Сэвинч Тоорил тухайд, Жэндиний захирагчаар томилогдсон гэснээс өөр ямар ч мэдээ байхгүй, үргэлжлүүлэн үр хүүхдийнх нь тухай дурджээ. Тиймээс Сэвинч Тоорил нь Жэндинд томилогдсоны дараа удалгүй нас барсан байж магад.

¹⁰ Gaogong shendaobei 高公神道碑, Yao Sui 姚燧, Mu an ji 牧庵集 23.

¹¹ Зүүлт 9-ийг үзнэ үү.

Тийнхүү монгол нутагт суух Сорхогтан бэхи хатан хятадгазар Жэндинийг захирахдаа тус нутгийн түшмэдийг дуудаж, уулзаж байсан жишээ олныг дурдаж болно. Тухайлбал, Таван замын түмэн Ши Тяньзэ-д захиргаан дор цэргийн болон шүүх хэргийг эрхлэн шийтгэж байсан Ван Шоудао (Wang Shoudao, 王守道) нь Жэндин Тулуйн гэр бүлийн захиргаанд орсноос хойш жил бүр Сорхогтан бэхи хатанд бараалхаж байжээ.¹² Харин Ши Гэ-гийн хувьд, хятад дахь эзэмшил нутгийг захирах түшмэлийн хувиар Сорхогтан бэхи хатанд дуудагдан, Жэндинээс Монгол нутагт ирж байсан уугэвэл, тийм бус бололтой. Чингис хааны байгуулсан Их Монгол Улсад дагаар орсон улс, аймгуудын хувьд үндсэн 6 зүйлийн үүрэг оногдож байв.¹³

Түүний нэг нь, “барьцааны хүн илгээх” бөгөөд хятадгазрыг захирах тэргүүн түшмэлийн хүү, дүү нар ч мөн адил үүрэг хүлээж байв.¹⁴ Бодит жишээ дурдвал, Жэндин замын Гаочэн (Gao-cheng) шианий захирагч (ling, 令)-аар ажиллаж байсан Дун Вэньбин (Dong Wen-bing, 董文炳) 1250 онд Сорхогтан бэхи хатан эзэмшил нутгийн хятад захирагчийн хүүг дуудсанд хүү Дун Вэньюн (Dong Wen-yong, 董文用)-ийг дагуулан Хархорумд ирж, Сорхогтан бэхи хатанд бараалхсан бөгөөд түүнээс хойш Вэньюн Хубилайн дэргэд хүчин зүтгэх болжээ.¹⁵ Монгол нутаг дахь барьцааны Вэньюнний нэгэн адил эзний шадар цэрэг болох хэшигтэн болж, эзэнт гүрний их хаан эсвэл язгууртаны дэргэд суралцан, дараа үеийн хаан болон хан хөвгүүдийн итгэлт сайд түшмэл болон бэлтгэгдэж байв.¹⁶ Тиймээс 1236 оны улаан бичин жил монгол ноёдод эзэмшил нутаг, иргэн олгоход Жэндин Тулуйн гэр бүлийн эзэмшил болсон, улмаар Жэндиний захирагч Ши Тяньзэ хүү Ши Гэ-гээ монгол нутагт суух эзний дэргэд барьцааны хүнээр илгээх үүрэг хүлээж байжээ.

4. Тулуйн гэр бүлийн үндсэн Монгол нутаг дахь эзэмшил газар хаагуур байсан бэ?

Энэ талаар миний бие өмнө судлаад, Тулуйн гэр бүлийн эзэмшил нутаг Хархорумаас баруун тийш, Хангайн нуруунд байсан, тэднийх энэ нутагт Чингис

¹² Юан улсын судар, дэвтэр 153, Ван Шоудао-гийн шастир.

¹³ Гуулин улсын судар, дэвтэр 26, Yuanzong shijia 元宗世家, тэмдэглэл 2, Тавдугаар оны 3 сарын “Wotaizu Chengjis huangdi zhidu 我太祖成吉思皇帝制度; Юан улсын судар, дэвтэр 209, An-nan буюу Вьетнамын шастирт мөн адил тэмдэглэл буй

¹⁴ Ebisawa Tetsuo. *Mongoru teikoku no tōhō sanōke ni kansuru shomondai, Saitama daigaku kiyō, Kyōiku gakubu, jinbun-shakai kagaku*, 21, 1972, 36-37.

¹⁵ Юан улсын судар, дэвтэр 156, Дун Вэньбин-ий шастир, мөн дэвтэр 148, Дун Вэньюнний шастир.

¹⁶ Ганьсу мужийн Линтао фу (Lintao fu, 臨洮府) бол Өгэдэйн хүү Хөдэн (Küden)-ы өмч нутаг бөгөөд Линтао-гийн захирагч Жао Агэпан (Zhao A-ge-pan, 趙阿哥潘) нь хүү Зун Ши (Zhong Xi, 重喜)-г Хөдэний дэргэд хэшигтэн болгожээ. Хожим нь Зун Ши Линтао мужийн түмэн (元帥 Yuan-shuai = 万户 tьмен), Линтао мужийн даргач болж, Хөдэний гэр бүлийн эзэмшил нутгийн захирагчаар болсон юм. Юан улсын судар, дэвтэр 123, Жао Агэпан-ий шастир.

хааны үеэс сууж ирсэн хэмээн үзсэн билээ.¹⁷

Тухайлбал, Жэндинээс Тулуйн гэр бүлийн нутаг Хангайн нуруу хүртэл зорчсон Жан Дэхуй (Zhang Dehui, 張德輝)-гийн замын тэмдэглэлийг¹⁸ задлан шинжсэн билээ. Жан Дэхуй бол Ши Тяньзэ-гийн Жэндиний захиргаанд албан хэргийн нярав болж, 1235 онд Ши Тяньзэ-г өмнө зүг довтлоход хамт явж, цэргийн өртөөг хариуцаж явсан хүн билээ.

Түүний аяллын тэмдэглэлээс үзэхэд, Жан Дэхуй 1247 оны билгийн тоололоор 6 сард Жэндинээс гарч, Хангайн нуруун дахь эзний гэрт¹⁹ очжээ. Түүний аялалын маршрут дараах мэт.



Зураг 2. Жэндин зам

Хүснэгт 2. Жан Дэхуйн аялалын маршрут

1247 он	Өгийнуурын баруун талын Киданы хотын тууриас баруун хойш 1 өртөө Моринтолгой (馬頭, Ma-tou) ууланд хүрсэн. Моринтолгой уулын ар хормойгоос баруун урагш Улаанчихэн (赤耳) буюу Тамирын хөндийд ирсэн. Зүүн хойш 1 өртөө Чулуун дов (Shihou, 石垓)-д ирсэн. Чулуун довоос баруун урагш 3 өртөө газарт, зүүн хойт зүгт урсах Чулуут (唐古, Tang-gu) голыг гаталж, цаад эрэгт гарсан. Цаад эрэгт орших өндөр уулын энгэр дэх ноёны зусланд очсон.
8 сар	Зуслангаас хөдөлж Чулуун дов, Улаанчихэнээр дамжин, зүүн хойш Туо (Tuo, 陀) ууланд хүрсэн.
9 сарын 9	Их ордонд (Yeke Ordon, 大牙帳) очив. 10 сарын дундуур уулан дахь өвөлжөөнд хүрэв.

¹⁷ Matsuda Kōichi. *Toruike no hangai no yūbokuchi, Ritsumeikan bungaku* 537, 1994, 285-304.

¹⁸ Sabei jixing, 塞北紀行, Wang Yun 王惲, Qiu run xiansheng Daquan wenji 秋潤先生大全文集100; *Юан улсын судар*, дэвтэр 163, Жан Дэхуйн шастир.

¹⁹ *Юан улсын судар*, дэвтэр 163, Жан Дэхуйн шастир, Жан Дэхуйг Шизү буюу Хубилайн гэрт очсон гэдэг. Гэвч дээр дурдсан түүний замын тэмдэглэл буюу уг эхэд, хэнийд очсоноо зөвхөн “ноён” гэх ганц үгээр тэмдэглэсэн буй. Хэрэг Жан Дэхуй үнэхээр Хубилайнд очсон бол “Хубилай” хэмээн тодорхой бичмээр мэт. Доор дурдсанчлан, “Ариг бөхийн үймээн”-ий үед “нэгэн ноён” Ши Гэ-г дуудаж, Хубилайтай тэмцэлдэх хэрэгт татан оруулсан тухай мэдээ бий (Зүүлт 9). Тэрхүү “нэгэн ноён” нь Аригбөх болно. Хубилайн ноёрхол тогтсоноос хойш, түүнтэй тэмцэлдсэн Аригбөхийн нэрийг ил хэлэхээс цээрлэж, “нэгэн ноён” хэмээн бичсэн болов уу. Тиймээс Жан Дэхуй замын тэмдэглэл дэх “ноён” хэмээх үгийг дээрх мэт утгаар хэрэглэсэн мэт. *Юан улсын сударын* Жан Дэхуйн шастирын тухайд, судрыг эмхэтгэх явцад зориуд Хубилай хэмээн засаж бичих боломжтой билээ.

1248 оны 1 сарын 3	Их ордонд зочлов. 15-нд баруун урагш гарсан. 2-р сарын дундуур Улаанчихээр дамжин зүүн тийш явсан. Моринтолгой (Ma-tou) ууланд усны шувуу (нуур?) агнав.
4 сарын 9	Их ордонд одов. Өртөө дамжин зуслан өөд.

Дээрх хүснэгтээс, Жан Дэхуйн харьяат “ноён” хэрхэн бэлчээр сэлгэн нүүдэллэж байсныг мэдэж болохоор байна. Тэрхүү бэлчээр нутаг нь зүүн зах Моринтолгой уулаас Тамирын голын дагуух Улаанчихэн (忽蘭赤斤)-ээр дамжаад, баруун зах Чулуут голд хүрч байжээ. Жан Дэхуй харьяат ноёныг дагаж, дээрх мэт нутаг сэлгэж нүүж байжээ.²⁰

“Цагаан хэрмийн умардад аялсан тэмдэглэл”-д, Улаанчихэн хэмээн газрын нэрийн тухай “Уулын нэр, хэлбэр нь улаан чихтэй адил учир чингэж нэрлэсэн” хэмээн тайлбарласан буй. Тайхар чулуу нь Хойд Тамирын голын хөндийд орших агаад Улаанчихэн хэмээх нь одоогийн Улаанчих (赤耳) уул, Тайхар чулуунаас зүүн хойш Хойд Тамирын голыг яльгүй уруудаад, 14-15 км орчимд голын баруун эрэгт оршино (Зураг 2). Миний бие 1998 онд, хээрийн судалгаа хийж түүгээр явж байхдаа ч Улаанчих уулыг Тайхар чулууны дэргэдээс харж байсан, 2013 онд ч Тайхар чулуунд хүрэхээс өмнөхөн Хойд Тамирын голын нөгөө эрэг дээрээс зургийг авч байсан юм.²¹ Энэ уул үнэхээр дээр дурдсанчлан улайж харагдах хадан уул бөгөөд чихтэй адил хэлбэртэй болно.

Энэ уулын хэлбэр байдлаас үзэхэд, Жан Дэхуй эзнийгээ даган нутаг бэлчээр сэлгэж, одоогийн Улаанчих уулын орчмоор явж байсан гэдэг нь гарцаагүй. Морин толгойгоос Чулуут гол хүртэлх нутаг буюу Тулуйн гэр бүлийн нутагт Тайхар чулуу багтаж байсан нь маргаангүй.

Тиймээс Сорхогтан бэхи хатан, Хубилай нарын Тулуйн үр хүүхэд буюу ноёнтонгоо уулзахаар очсон Ши Гэ нь Тайхар чулуун дээр очсон байх бүрэн бололцоотой. Түүгээр үл барам Жан Дэхуйн тэмдэглэлд, билгийн тоололын 2, 8-р сард Улаанчих уулаар явж өнгөрсөн гэж буй. Бэхэн бичээс дэх “八月 найман сар” хэмээх үг нь дээрх хугацаатай яг тохирч, зуслангаас өвөлжөөнд нүүх цаг үе (намрын эхэн)-тэй таарч байна. Ши Гэ Тулуйн гэрийнхэнийг дагалдаж, намаржаанд байх үед Тайхар чулуун дээр ирсэн мэт.

Юан улсын судар дахь Ши Гэ-гийн шастирт, Мөнх хаан Ши Тяньзэ-д Вэйжоу (衛州, Wei-zhou)-гийн харьяаны 5 сиань (Ji, 汲, Zuocheng, 胙城, Xinx-
iang, 新鄉, Huo-jia, 獲嘉, Ou-men, 藕門) -ийг эзэмшил нутаг болгон өгөхөд, тэрбээр

²⁰ Хавсаргасан зурагт үзүүлсэн хаваржаа, зуслан, намаржаа, өвөлжөөний байршлын тухайд, дээр дурдсан Н.Шираиши-гийн бүтээл, 303-306 дэх Хубилайн нутгийн талаарх түүний тайлбар, газрын зурагт тулгуурлан, миний бие тэмдэглэсэн болно. Н.Шираиши бээр, Хубилайн хаваржаа нь Тамирын голын хойт эргийн уул, зуслан нь Чулуут гол, намаржаа нь Улаанчихэн уул, өвөлжөө нь одоо Их уул хэмээгдэх уулын өвөр хэмээн үзсэн буй. Зурагт хаваржаа болох Моринтолгой уулыг Тамирын голын баруун эрэгт тэмдэглэснийг зүүн эрэгт болгосноор өөр засвар оруулаагүй болно.

²¹ Зүүлт 2; Noriyuki Shiraishi. *Mongoru teikokushi no kōkogakuteki kenkyū*, Dōseisha, 2002, 306

Вэйжоу-гийн тэргүүн түшмэл (Jiedushi, 節度使)-ээр томилогдсон тул энэ үед Ши Гэ хэдийн Хятад нутагт буцаж ирсэн байжээ. Түүний дараа Мөнхийг Сичуанд довтлоход эцэг хүү хоёул оролцжээ. Мөнх хаан Сичуанд нас барангуут 1260 оны сүүлээр дүү Аригбөх нь Хархорумын баруун этгээд Алтан голд хаан ширээнд (Газрын зураг 1), нөгөө талд Хубилай Өвөр Монголын Долоннуур (хожмын Шанду)-т хаан ширээнд сууснаар өмнөд, умардад хоёр улс зэрэгцэн орших болов.

Аригбөх, Хубилай нарын тэмцэлд, эцэг Ши Тяньзэ нь Хубилайн талд үлдсэн бол хүү Ши Гэ нь Аригбөхийн талд орж, түүний хамт умар зүг Енисей мөрний эх Kemkemjü'üd (Qing-zhou, 謙州) рүү зугтаж, тэнд 5 жил суугаад Аригбөх бууж өгсөнөөр 1264 онд эцгийн дэргэд буцаж ирснээс²² хойш эцэг хүү хоёул Хубилайн төрд хүчин зүтгэх болжээ. Ши Гэ тийнхүү Аригбөхийн талд орсон нь, монгол нутагт Тулуйн гэр бүлд барьцаанд байх хугацаандаа түүнтэй сайн харьцаатай байсных болов уу.

Дүгнэлт

Дээр дурдсанаас үзэхэд, 1236 оны улаан бичин жил монгол ноёдод эзэмшил нутаг, иргэн олгоход, Тулуйн гэр бүл Жэндин нутгийг эзэмших болжээ. Улмаар эзэмшил нутгийн түшмэд өөрсдийн ахмад хүүг монгол нутаг дахь эзний гэрт барьцаанд илгээх Чингис хааны тогтоосон дүрмийн дагуу Жэндиний түшмэл Ши Тяньзэ нь ахмад хүү Ши Гэ-г Тулуйн гэр бүлийн уугуул нутаг Хангай уулаар нутаглах Сорхогтан бэхи хатны дэргэд барьцааны албанд илгээжээ. Тулуйн гэр бүлийн үндсэн нутаг нь Хангайн нуруу, одоогийн Улаанчих уул орчмоор төвлөрч байсан бөгөөд Тайхар чулуу нь Улаанчих уулын ойр оршдог.

Тайхар чулууны бэхэн бичээст дурдагдах, улаагчин тахиа (1237) оны намар найман сард Тайхар чулуун дээр очсон “Жэндиний Ши Гэ” гэгч бол Жэндиний хятад захиргааг тэргүүлэгч Ши Тяньзэ-гийн ахмад хүү болно. Ши Гэ Тайхар чулуун дээр очсон шалтгааны тухайд, эзэн болох Тулуйн гэр бүл, тухайлбал Сорхогтан бэхи хатны дэргэд барьцааны алба гүйцэтгүүлэхээр эцэг Ши Тяньзэ нь түүнийг илгээсэн хэрэг бөгөөд 8-р сард эзний нүүдлийг дагалдан явах зуур энэ газраар дайрч өнгөрсөн болов уу.

Ши Гэ-гийн бэхэн бичээс бичигдсэн учир дээрх мэт. Юан улсын судар, дэвтэр 155, Ши Тяньзэ-гийн шастирт, Ши Гэ-г Аригбөхийн талд орж байсан тухай огт дурдсангүй. Аригбөхөд зүтгэж байсан явдал нь Хубилайн ноёрхол тогтсоны дараа эргэж ирсэн Ши Гэ-гийн хувьд сөхөж гаргаад байхааргүй хэрэг байсан буй за. Тиймээс Ши Гэ 16 буюу түүнээс бага насандаа монгол нутаг дахь

²² Ши Гэ-гийн намтар болох Yao Sui 姚燾, Pingzhang zhenshi shigong shendao bei 平章政事史公神道碑 (Su Tianjue 蘇天爵, Guochao wenlei, 國朝文類 62)-т, “一王召公、偕北絕漠留謙州、依儲氏姑居五年而歸” буюу “Нэгэн ноён Ши Гэ-г дуудан ирүүлж, хамтаар умар зүг Kemkemjü'üd-д одоож суугаад, таван жилийн дараа буцаж ирсэн” хэмээжээ.

Тулуйн гэр бүлд байсан бахархам намтар нь Юан улсын сударт орсонгүй. Ийнхүү “Бичээс” төслийн 2013 оны судалгааны үр дүнд Юан улсын сударт бичигдээгүй нэгэн түүх буюу Ши Гэ-гийн тухай баримт шинээр олдсон юм.

Энэ өгүүлэл нь Grants-in-Aid for Scientific Research, 2013 (Research Project Number 23320155)-ийн судалгааны үр дүнгийн нэг хэсэг болно.

Япон хэлнээс орчуулсан Б.Сэржав, О.Оюунжаргал

Abstract: In the summer of 2013, an ink inscription written in Chinese characters was found on Taikhar Chuluu in Ikh Tamir soum, Arkhangai aimag as a result of the research conducted for the Mongolia-Japan joint project, Inscription III. In this article, the inscription was studied, thus yielding the following conclusion. The “Shi Ge from Zhengding”, the person whose name appears in the ink inscription and who visited Taikhar Chuluu in the August of the 1237, was the eldest son of Shi Tianze, the governor of Zhengding. The Zhengding county of China was allotted to the family of Tolui in Mongolia as the Mongol lords were given lands and people in 1236. The governor Shi Tianze, according to the rules laid down by Chinggis khaan, then sent his eldest son Shi Ge to his lord, the family of Tolui (or the queen Sorghaghtani Beki) to stay in Mongolia. Thus the inscription on Taikhar Chuluu was left by Shi Ge who visited the rock along the way to accompany his lord on the trek in the August of 1237.